



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг тогтоох, хөнгөлөх, чөлөөлөх, төлөх, хураах болон түүнийг тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль тогтоомж

2.1.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль тогтоомж нь Татварын ерөнхий хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Улсын тэмдэгтийн хураамж

3.1.Төрийн эрх бүхий байгууллагаас энэ хуульд заасан үйлчилгээ үзүүлсний төлөө иргэн, хуулийн этгээдийн төлж байгаа мөнгөн хөрөнгийг улсын тэмдэгтийн хураамж /цаашид "тэмдэгтийн хураамж" гэх/ гэнэ.

3.2./Энэ хэсгийг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

4 дүгээр зүйл.Тэмдэгтийн хураамж төлөгч

4.1.Тэмдэгтийн хураамж төлөх үйлчилгээгээр үйлчлүүлж байгаа дараахь этгээд тэмдэгтийн хураамж төлөгч байна:

4.1.1.Монгол Улсын иргэн;

4.1.2.гадаадын иргэн, харьяалалгүй хүн;

4.1.3.төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, түүний салбар, төлөөлөгчийн газар, улс төрийн нам, хөдөлгөөн, сан, шашны байгууллага;

4.1.4.гадаад улс дахь Монгол Улсын элчин сайдын яам, консулын газраар дамжуулан үйлчилгээ авч байгаа иргэн, хуулийн этгээд.

5 дугаар зүйл.Тэмдэгтийн хураамж хураах үйлчилгээний төрөл

5.1.Тэмдэгтийн хураамжийг дор дурдсан үйлчилгээнд хураана:

5.1.1.шүүхээс эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх;

5.1.2.арбитрын ажиллагаанд шүүх оролцох;

5.1.3.нотариатын үйлчилгээ үзүүлэх;

5.1.4.иргэний бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх;

5.1.5.консулын үйлчилгээ үзүүлэх;

5.1.6.тээврийн болон өөрөө явагч хэрэгслийг бүртгэх, жолоодох зөвшөөрөл олгох;

5.1.7.Хувийн хамгаалалтын тухай хуулийн 6.1-д заасан хувийн хамгаалалт-эрхлэх тусгай зөвшөөрөл олгох;-
/Энэ заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./

5.1.8.сонин, сэтгүүл, радио, телевизийг бүртгэх;

- 5.1.9.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх;
- 5.1.10.Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын байгууллага, түүний салбар, төлөөлөгчийн газрыг бүртгэх;
- 5.1.11.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд заасан үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох;
[/Энэ заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)
- 5.1.12.Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох;
[/Энэ заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)
- 5.1.13.Аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан эрх олгох;
[/Энэ заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)
- 5.1.14.Байгалийн ургамлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөвшөөрөл олгох;
- 5.1.15.Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 5.2-т заасан үйл ажиллагаа;
- 5.1.16.Ус цаг уур, орчны шинжилгээний тухай хуулийн 8.1-д заасан үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох;
- 5.1.17.Усны тухай хуулийн 11.1.8, 20.3-т заасан усны мөргөжлийн байгууллагад эрх олгох, хугацааг сунгах, мөн хуулийн 23.1-д заасны дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ус ашиглах эрх олгох;
[/Энэ заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)
- 5.1.18.Ойн тухай хуулийн 12.1.10-т заасны дагуу ойн мөргөжлийн байгууллагад эрх олгох;
[/Энэ заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)
- 5.1.19.Ахуйн болон үйлдвэрлэлийн хөг хаягдлын тухай хуулийн 14.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох;
[/Энэ заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)
- 5.1.20.Аюултай хөг хаягдлын импорт, хил дамжуулан тээвэрлэлтийг хориглох, экспортлох тухай хуулийн 5.2-т заасан зөвшөөрөл олгох;
[/Энэ заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)
- 5.1.21.Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуулийн 5.1.4, 5.1.5-д заасны дагуу зөвшөөрөл, гэрчилгээ олгох;
- 5.1.22.Ан агнуурын тухай хуулийн 7.1, 11.1-д заасан зөвшөөрөл олгох;
[/Энэ заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)
[/Энэ заалтад 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)
- 5.1.23.Амьтны аймгийн тухай хуулийн 15.2, 17.2, 17.3, 23.1-д заасны дагуу зөвшөөрөл олгох;
[/Энэ заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)
- 5.1.24.Боловсролын тухай хуулийн 20.1-д заасан тусгай зөвшөөрөл олгох;
- 5.1.25.Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 8.6-д заасны дагуу гэрчилгээ олгох, мөн хуулийн 9.4, 10.5, 11.3, 17.10, 20.1, 20.3-т заасан үйл ажиллагаанд зөвшөөрөл олгох;
[/Энэ заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)
- 5.1.26.Эрчим хүчний тухай хуулийн 13, 20 дугаар зүйл, Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 7.1-д заасан тусгай зөвшөөрөл олгох;
- 5.1.27.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 12.4, 17.9-д заасны дагуу зөвшөөрөл олгох;
[/Энэ заалтад 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)
- 5.1.28.Хүчнээний тухай хуулийн 9.3-т заасан үйл ажиллагаа;
[/Энэ заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)
- 5.1.29.Хувиргасан амьд организмын тухай хуулийн 6.1, 13.1-д заасан зөвшөөрөл олгох;
- 5.1.30.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 6.1-д заасан зөвшөөрөл олгох;
[/Энэ заалтад 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)
- 5.1.31.Эрүүл мэндийн тухай хуулийн 16, 17 дугаар зүйлд заасан үйл ажиллагаа;
- 5.1.32.Иргэний нисэхийн тухай хуулийн 15.2-т заасан гэрчилгээ, зөвшөөрөл олгох;
[/Энэ заалтад "Иргэний нисэхийн тухай хуулийн 11.2.2-т" гэснийг "Иргэний нисэхийн тухай хуулийн 15.2-т" гэж 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)
[/Энэ заалтад 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

- 5.1.33.Харилцаа, холбооны тухай хуулийн 21.2-т заасан тусгай зөвшөөрөл олгох;
[/Энэ заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)
- 5.1.34.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 12.3-т заасан стандартыг бүртгэх;
[/Энэ заалтыг 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)
- 5.1.35.гаалийн байгууллагаас энэ хуулийн 32 дугаар зүйлд заасан ажил, үйлчилгээ эрхлэхэд зөвшөөрөл, гэрчилгээ олгох;
[/Энэ заалтад 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)
- 5.1.36.гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх чиглэлээр зөвшөөрөл олгох;
[/Энэ заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)
- 5.1.37.аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, хотын Зөвлөл, хотын Захирагч, тухайн шатны төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл олгох;
[/Энэ заалтад 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)
[/Энэ заалтад 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)
- 5.1.38.шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварт патент, барааны тэмдэгт гэрчилгээ олгох, патентыг хүчинтэй байлгах болон лицензийн гэрээг бүртгэх;
- 5.1.39.зохиогчийн эрхэд хамаарах бүтээл бүртгэх;
- 5.1.40.эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх;
- 5.1.41.газрыг өмчлүүлэх, ашиглуулах, эзэмшүүлэх зөвшөөрөл олгох, бүртгэх;
- 5.1.42.Газрын хэвлийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу газрын хэвлийг олгох;
- 5.1.43.баримт бичиг баталгаажуулж, "Апостиль" гэрчилгээ олгох.
- 5.1.44.шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр эрх зүйн маргаан зохицуулах.
[/Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)
- 5.1.45.Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 38.2-т заасан үйлчилгээ үзүүлэх.
[/Энэ заалтыг 2015 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)
- 5.1.46.Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7.3-д заасан тусгай зөвшөөрөл олгох.
[/Энэ заалтыг 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)
- 5.1.47.музейн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан зөвшөөрөл олгох.
[/Энэ заалтыг 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)
- 5.1.48.Соёлын тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу зөвшөөрөл олгох.
[/Энэ заалтыг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)
- 5.1.49.Кино урлагийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу зөвшөөрөл олгох.
[/Энэ заалтыг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)
- 5.1.50.Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан үйлчилгээ.
[/Энэ заалтыг 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)
- 5.1.51.Цахим гарын үсгийн тухай хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу тоон гарын үсгийн гэрчилгээ олгох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох;
[/Энэ заалтыг 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)
- 5.1.52.Санхүүгийн зохицуулах хороонд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгэх.
[/Энэ заалтыг 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)
- 5.1.53.Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох, сунгах, гадаадын ажиллах хүчний хөдөлмөр эрхлэлттэй холбоотой үйлчилгээ.
[/Энэ заалтыг 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)
- 5.1.54.Генетик нөөцийн тухай хуулийн 8.1.3, 8.5.2, 17.3-т заасан тусгай зөвшөөрөл, гарал үүслийн тодорхойлолт, хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгох.

[/Энэ заалтыг 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

5.1.55.Шүүх шинжилгээний тухай хуульд заасан зарим шүүх шинжилгээ хийх болон түүнд холбогдох үйлчилгээ үзүүлэх;

[/Энэ заалтыг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

5.1.56.Шүүх шинжилгээний тухай хуульд заасан шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох.

[/Энэ заалтыг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

5.1.57.Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах.

[/Энэ заалтыг 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

6 дугаар зүйл.Тэмдэгтийн хураамжийн хэмжээг тогтоох

6.1.Энэ хуулийн 6.2, 6.3-т зааснаас бусад тэмдэгтийн хураамжийн хэмжээг энэ хуулиар тогтооно.

6.2.Энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, 11.4, 11.5 дахь хэсэг, 12 дугаар зүйл, 15, 17, 18, 19, 20 дугаар зүйл, 201 дүгээр зүйл, 21 дүгээр зүйлийн 21.1.8, 21.1.9, 21.1.12, 21.1.13, 21.1.15, 21.1.16, 21.1.17, 21.1.24, 21.1.26, 21.1.27, 21.1.28, 21.1.30, 21.1.32, 21.1.33, 21.1.34, 21.1.35, 21.1.36, 21.1.37, 21.1.38, 21.1.40, 21.1.41, 21.1.43 дахь заалт, 221 дүгээр зүйл, 24 дүгээр зүйл, 25 дугаар зүйлийн 25.1.2, 25.1.3, 25.1.7, 25.1.8, 25.1.9, 26 дугаар зүйлийн 26.1.2, 26.1.6, 26.1.7, 26.1.8, 26.1.9 дэх заалт, 26.2, 26.3, 26.4 дэх хэсэг, 27 дугаар зүйлийн 27.1.1, 27.1.4, 27.1.5, 27.1.6 дахь заалт, 27.3, 27.4, 27.5 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 28.1.8, 28.1.9 дэх заалт, 29 дүгээр зүйлийн 29.1.4, 29.1.5, 29.1.6, 29.1.7, 29.1.8, 29.1.9, 29.1.10, 29.1.11 дэх заалт, 32 дугаар зүйл, 33 дугаар зүйлийн 33.1.3 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.1, 35.1.2, 35.1.3 дахь заалт, 37 дугаар зүйл, 40 дүгээр зүйлд заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг энэ хуульд заасан хязгаарт багтаан Засгийн газар тогтооно.

[/Энэ хэсэгт 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

[/Энэ хэсэгт 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсгийг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

[/Энэ хэсэгт 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсгээс "29.1.1, 29.1.2, 29.1.3." гэснийг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар хассан./](#)

[/Энэ хэсэгт 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

6.3.Энэ хуулийн 29.1.12, 29.1.14, 35.1.4, 35.1.5, 35.1.6, 35.1.7, 35.1.8, 35.1.9, 35.1.10, 35.1.11, 35.1.12, 35.1.13, 35.1.15, 35.1.16, 35.1.17, 35.1.18, 35.1.21, 35.1.22 дахь заалт, 35.4, 35.5 дахь хэсэгт заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг энэ хуульд заасан хязгаарт багтаан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, улсын зэрэглэлтэй хотын Зөвлөл тогтооно.

[/Энэ хэсэгт 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

[/Энэ хэсэгт 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсгийг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

6.4.Монгол Улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газраас үзүүлэх энэ хуулийн 5.1.3, 5.1.4, 5.1.5, 10.6-д заасан тэмдэгтийн хураамж, визийн үйлчилгээний хөлсний хэмжээг Засгийн газар тогтооно. Тэмдэгтийн хураамжийн хэмжээг тогтоохдоо гадаад улстай харилцан адил байх зарчмыг баримтлах бөгөөд уг хэмжээг гадаад валютаар тогтоож болно.

[/Энэ хэсгийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

[/Энэ зүйлийг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

ХОЁРДУГААР БҮЛЭГ ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ

7 дугаар зүйл.Шүүхээс эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэхэд хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

7.1.Эрх зүйн маргааныг хянан шийдвэрлүүлэхээр өргөдөл, гомдол, нэхэмжлэл шүүхэд гаргах болон шүүхээс баримт бичиг олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

7.1.1.эд хөрөнгийн чанартай үнэлж болох нэхэмжлэлд нэхэмжлэлийн үнийн дүнгээс хамаарч тэмдэгтийн хураамж нь дараах хэмжээтэй байх:

Нэхэмжлэлийн үнийн дүн /төгрөгөөр/	Хураамжийн хувь, хэмжээ /төгрөгөөр/
0-130 000	4550 төгрөг.

130 001-650 000	4550 төгрөг дээр 130 000 төгрөгөөс давсан дүнгийн 3 хувийг нэмнэ.
650 001-1 300 000	20150 төгрөг дээр 650 000 төгрөгөөс давсан дүнгийн 2.4 хувийг нэмнэ.
1 300 001-13 000 000	35750 төгрөг дээр 1 300 000 төгрөгөөс давсан дүнгийн 1.6 хувийг нэмнэ.
13 000 001-ээс дээш	222950 төгрөг дээр 13 000 000 төгрөгөөс давсан дүнгийн 0.5 хувийг нэмнэ.

[Энэ заалтыг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

7.1.2.эд хөрөнгийн бус, түүнчлэн үнэлэх боломжгүй нэхэмжлэлд 70 200 төгрөг;

[Энэ заалтад 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

7.1.3.хэрэгт байгаа нотлох баримтын хуулбар, түүнчлэн шүүхийн шийдвэр, магадлал, шийтгэвэр, гүйцэтгэх хуудас дахин олгоход хуудас тутамд 100 төгрөг.

[Энэ заалтад 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

7.1.4.шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой шүүхэд гаргах гомдолд энэ хуулийн 7.1.2-т заасан хэмжээгээр.

[Энэ заалтыг 2014 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

7¹дүгээр зүйл.Шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр эрх зүйн маргаан зохицуулахад хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

7¹.1.Эвлэрүүлэн зуучлалын журмаар маргаанаа зохицуулахаар шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид өргөдөл гаргахад 30 000 төгрөгийн тэмдэгтийн хураамж хураана.

[Энэ зүйлийг 2012 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

8 дугаар зүйл.Арбитрын ажиллагаанд шүүх оролцоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

8.1.Арбитрын ажиллагаанд шүүх оролцоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

8.1.1.арбитрын шийдвэрийг хүчингүй болгох, баталгаажуулах, гүйцэтгүүлэх тухай хүсэлт шийдвэрлэхэд нэхэмжлэлийн үнийн дүнгийн 0.1 хувь;

8.1.2.Арбитрын тухай хуульд заасан бусад асуудлаар шийдвэр гаргахад нэхэмжлэлийн үнийн дүнгийн 0.05 хувиар.

9 дүгээр зүйл.Нотариатын үйлчилгээ үзүүлэхэд хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

9.1.Нотариатын үйлчилгээ үзүүлэхэд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

9.1.1.үл хөдлөх эд хөрөнгийн холбогдолтой баримт бичиг гэрчлэхэд 4 400 төгрөг;

9.1.2.үл хөдлөх эд хөрөнгийн гэрээ гэрчлэхэд нөхөр, эхнэр, хүүхэд, эцэг, эхийн хувьд гэрээний үнийн дүнгээс 0.03 хувь, бусад хүнд 0.05 хувь;

9.1.3.эд хөрөнгийн бус үнэлэх боломжгүй гэрээ, хэлцэл гэрчлэхэд 1 100 төгрөг;

9.1.4.эд хөрөнгийн бус үнэлэх боломжгүй гэрээ, хэлцэлд өөрчлөлт оруулсан, хугацааг нь сунгасныг гэрчлэхэд 1 100 төгрөг;

9.1.5.эд хөрөнгө хөлслөх, түрээслэх гэрээ, хэлцэл гэрчлэхэд 1 100 төгрөг;

9.1.6.хуулийн этгээд үүсгэн байгуулах, татан буулгах баримт бичиг гэрчлэхэд 4 400 төгрөг;

9.1.7.хуулийн этгээд үүсгэн байгуулах, татан буулгах баримт бичигт өөрчлөлт оруулсан, хугацааг нь сунгасныг гэрчлэхэд 1 100 төгрөг;

9.1.8.хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөн байгуулах эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг нотариатаар гэрчлэхэд 2 000 төгрөг;

9.1.9.аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл болон зөвшөөрөлтэй холбогдсон баримт материал гэрчлэхэд 20 000 төгрөг;

9.1.10.итгэмжлэл гэрчлэхэд 1 100 төгрөг;

9.1.11.баримт бичгийг болон түүний хуулбарын үнэн зөвийг гэрчлэхэд хуудас тутмаас 110 төгрөг;

9.1.12.баримт бичгийн орчуулгыг гэрчлэхэд хуудас тутмаас 300 төгрөг;

9.1.13.баримт бичигт зурсан гарын үсэг гэрчлэхэд 2 500 төгрөг;

- 9.1.14.гэрчлэгдсэн баримт бичгийн хуулбарыг гэрчлэхэд хуудас тутмаас 110 төгрөг;
- 9.1.15.үйлчлүүлэгчийн хүсэлтээр үндсэн материалыг шалгахад 4 400 төгрөг;
- 9.1.16.өв залгамжлах эрх, гэрээслэл гэрчлэхэд 1 100 төгрөг;
- 9.1.17.гэр бүлийн гишүүдийн дундаа хамтран болон дундаа хэсгээр өмчлөх эрхийг гэрчлэхэд 550 төгрөг;
- 9.1.18.өвлүүлэгчийн нөхөр, эхнэр, хүүхэд, эцэг, эхээс бусад хүнд өв залгамжлах эрхийн гэрчилгээ олгоход 10 000 төгрөг;
- 9.1.19.үнэт цаас өмчлөх эрхийн гэрчилгээ гэрчлэхэд 5 000 төгрөг;
- 9.1.20.хууль тогтоомжид заасан бусад үйлчилгээ үзүүлэхэд үнийн дүнгийн 1.2 хувь.
- 9.1.21.энэ хуулийн 9.1.2-9.1.5-д зааснаас бусад гэрээ, хэлцлийг гэрчлэхэд үнийн дүнгийн 1 000 000 хүртэл төгрөгөөс 0.02 хувь, 1 000 000 төгрөгөөс давсан дүнгээс 0.01 хувиар хураах.
- 9.2.Гэрээ, хэлцэлд өөрөөр заагаагүй бол тэмдэгтийн хураамжийг хэлэлцэн тохирогч талууд тэнцүү хувааж төлнө.

10 дугаар зүйл.Иргэний улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэхэд хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

[/Энэ зүйлийн гарчиг т 2018 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

~~10.1./Энэ хэсгийг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

~~10.2./Энэ хэсгийг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

10.3.Монгол Улсын иргэний үнэмлэх /цаашид "иргэний үнэмлэх" гэх/ олгох, түүнд тэмдэглэл хийхэд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

10.3.1.иргэний үнэмлэх олгоход 3 300 төгрөг;

[/Энэ заалт ад 2011 оны 6 дугаар сарын 9-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

~~10.3.2./Энэ заалтыг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

10.3.3.иргэний үнэмлэхийг 25, 45 настай иргэнд сольж олгоход 3 300 төгрөг;

10.3.4.иргэний үнэмлэхэд иргэний оршин суугаа газрын хаягийн өөрчлөлт хийхэд 1000 төгрөг;

[/Энэ заалт ад 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

10.3.5.оршин суух тодорхой хаяггүй Монгол Улсын харьяат иргэнд цагдаагийн байгууллагын тодорхойлолтыг үндэслэн тухайн оршин суугаа нутаг дэвсгэрийн сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар иргэний үнэмлэх олгоход 3 300 төгрөг.

[/Энэ заалтыг 2018 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

10.4.Гадаадад зорчих эрхийн бүртгэлд бүртгэхэд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

10.4.1.үндэсний энгийн гадаад паспорт олгоход 5 000 төгрөг;

[/Энэ заалт ад 2018 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

~~10.4.2.эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчийн хамт түр хугацаагаар гадаадад зорчих хүүхдэд үндэсний гадаад паспортод хавсаргах үнэмлэх олгоход 2 500 төгрөг;~~

[/Энэ заалтыг 2018 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

~~10.5./Энэ хэсгийг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

10.6.Гадаадын иргэн, харьяалалгүй хүнд Монгол Улсын виз, оршин суух зөвшөөрөл олгох, виз, оршин суух зөвшөөрлийн хүсэлтийг хянах, бүртгэх үйлчилгээ үзүүлэхэд доор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

[/Энэ хэсгийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

10.6.1.гадаадын иргэнд тус улсад албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл олгоход 60 000-150 000 төгрөг;

10.6.2.суралцах, мэргэжил дээшлүүлэх, дадлага, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх гадаадын иргэнд оршин суух зөвшөөрөл олгоход 12 000-30 000 төгрөг;

10.6.3.гадаадын иргэн, харьяалалгүй хүнд Монгол Улсад оршин суух үнэмлэх олгох, солиход 15 000-36 000 төгрөг;

[/Энэ заалт ад 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

10.6.4.гадаадын иргэн, харьяалалгүй хүний тус улсад албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрлийн хугацааг сунгахад 36 000-90 000 төгрөг;

- 10.6.5.харьяалалгүй хүнд гадаадад зорчих үнэмлэх олгох, үнэмлэхний хугацаа сунгахад 4800-12 000 төгрөг;
- 10.6.6.гадаадын иргэнд хувийн хэрэг хөтөлж, регистрийн дугаар олгоход 1200-3000 төгрөг;
- 10.6.7.гадаадын иргэн, харьяалалгүй хүний оршин суух үнэмлэхэд оршин суугаа хаягийн өөрчлөлт, бусад тэмдэглэл хийх тухай бүр 1000-2500 төгрөг;
- ~~10.6.8.хувийн хэрэг хөтөлж, регистрийн дугаар олгосон гадаадын иргэн, харьяалалгүй хүний баримт бичигт гадаадад зөрчсөн тэмдэглэл хийх тухай бүр 1000-2500 төгрөг;~~
- [/Энэ заалтыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)
- 10.6.9.Монгол Улсад хувийн хэргээр зорчих урилга олгоход 10 000-15 000 төгрөг;
- [/Энэ заалтад 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)
- 10.6.10.гадаадын иргэний талаар тодорхойлолт гаргахад 1000-2500 төгрөг;
- 10.6.11.гадаадын иргэн оршин суух болон зорчих үнэмлэхээ алдсан, үрэгдүүлсэн, гээгдүүлсэн, хүчингүй буюу ашиглах боломжгүй болгосон тохиолдолд шинээр буюу дахин олгоход 36 000-90 000 төгрөг;
- ~~10.6.12.гадаадын иргэнийг бүртгэхэд 1000-2500 төгрөг;~~
- [/Энэ заалтыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)
- 10.6.13.гадаадын иргэнд визийн зөвшөөрөл олгоход /хүн тус бүрээр/ 1000-2500 төгрөг;
- ~~10.6.14.гадаадын иргэн, харьяалалгүй хүнд орон нутагт явахад зөвшөөрөл олгоход /хүн тус бүрээр/ 1000-2500 төгрөг;~~
- [/Энэ заалтыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)
- 10.6.15.нэг удаагийн орох виз олгоход 115 000-270 000 төгрөг;
- [/Энэ заалтыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)
- 10.6.16.хоёр удаагийн орох виз олгоход 160 000-320 000 төгрөг;
- [/Энэ заалтыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)
- 10.6.17.зургаан сарын олон удаагийн виз олгоход 210 000-450 000 төгрөг;
- [/Энэ заалтад 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)
- 10.6.18.зургаан сараас нэг жил хүртэлх хугацаагаар олон удаагийн виз олгоход 460 000-750 000 төгрөг;
- [/Энэ заалтад 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)
- 10.6.19.дамжин өнгөрөх нэг удаагийн виз олгоход 36 000-90 000 төгрөг;
- 10.6.20.дамжин өнгөрөх хоёр удаагийн виз олгоход 72 000-180 000 төгрөг;
- 10.6.21.дамжин өнгөрөх олон удаагийн виз олгоход 96 000-240 000 төгрөг;
- ~~10.6.22.хувийн хэрэг хөтөлж, регистрийн дугаар олгосон гадаадын иргэнд нэг болон хоёр удаагийн гарах орох виз өлгөхөд 18 000-45 000 төгрөг;~~
- [/Энэ заалтыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)
- 10.6.23.нэг визэд хавсаргасан иргэдийн визийг салгах, визийг шилжүүлэн олгоход 16 000-45 000 төгрөг;
- 10.6.24.визийн хугацааг долоо хүртэл хоногоор сунгахад 27 000-67 500 төгрөг, дараагийн хоног тутамд 3600-9000 төгрөг;
- 10.6.25.визийн ангилал өөрчлөхөд 36 000-90 000 төгрөг;
- 10.6.26.олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газар нээн ажиллуулах зөвшөөрөл өгч, гэрчилгээ олгоход 900 000-2 250 000 төгрөг;
- 10.6.27.олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын зөвшөөрөл өгч, гэрчилгээний хугацааг сунгахад 360 000-900 000 төгрөг;
- 10.6.28.олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэлийн гэрчилгээг дахин олгоход 60 000-150 000 төгрөг;
- 10.6.29.Монгол Улсын харьяат болох, харьяатаас гарах, иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлтийг хянан шийдвэрлүүлэхэд 60 000-150 000 төгрөг.
- 10.6.30.гадаадын иргэний бүх төрлийн виз, визийн болон оршин суух зөвшөөрөл олгох хүсэлтийг хянан, энэ хуулийн 10.6.1, 10.6.2, 10.6.3, 10.6.4, 10.6.5, 10.6.6, 10.6.7, 10.6.9, 10.6.10, 10.6.11, 10.6.13, 10.6.15, 10.6.16, 10.6.17, 10.6.18, 10.6.19, 10.6.20, 10.6.21, 10.6.23, 10.6.24, 10.6.25, 10.6.26, 10.6.27, 10.6.28, 10.6.29-д заасан үйлчилгээг татгалзсан

тохиолдолд тэмдэгтийн хураамжийг буцаан олгохгүй.

[/Энэ заалтыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

[/Энэ хэсгийг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

10.7.Энэ хуулийн 10.6-д заасан гадаадын иргэнд үзүүлэх үйлчилгээг яаралтай буюу хилийн боомт дээр үзүүлэх тохиолдолд хураамжийн хэмжээг хоёр дахин нэмэгдүүлэн хураана.

[/Энэ хэсгийг 2011 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

11 дүгээр зүйл.Консулын үйлчилгээ үзүүлэхэд хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

11.1.Гадаадад зорчих эрхийн бүртгэлд бүртгэхэд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

11.1.1.үндэсний энгийн гадаад паспорт олгоход 12 500 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.1.2.дипломат, албан паспорт олгоход 30 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.1.3.Монгол Улсад буцах үнэмлэх олгоход 22 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.1.4.үндэсний гадаад паспортын хүчинтэй хугацааг сунгахад 2500 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.1.5.хүүхдийн үнэмлэх олгоход 2000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.2.Монгол Улсад зорчих гадаадын иргэн, харьяалалгүй хүнд виз олгоход энэ хуулийн 10.6-д заасан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана.

11.3.Консулын үйлчилгээг яаралтай үзүүлэх тохиолдолд энэ хуулийн 10.6-д заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг ажлын 8 цагийн дотор бол хоёр дахин нэмэгдүүлж, амралт, баяр ёслолын өдөр бол гурав дахин нэмэгдүүлэн хураана.

11.4.Консулын нотариатчийн үүрэг гүйцэтгэгчийн үйлчилгээнд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

11.4.1.эд хөрөнгийн бус үнэлэх боломжгүй гэрээ, хэлцэл гэрчлэхэд 18 000-54 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.4.2.эд хөрөнгийн бус үнэлэх боломжгүй гэрээ, хэлцэлд өөрчлөлт оруулсан, хугацаа сунгасныг гэрчлэхэд 7500-22 500 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.4.3.эд хөрөнгө хөлслөх, түрээслэх гэрээ, дүрэм гэрчлэхэд 23 000-69 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.4.4.Монгол Улсын газрын харилцаанд холбогдох гэрээнээс бусад хэлцэл /гэрээ, итгэмжлэл зэрэг/-ийг гэрчлэхэд 52 000-156 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.4.5.баримт бичигт консулын баталгаа гаргахад 1500-4500 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.4.6.баримт бичгийг болон баримт бичгийн хуулбарын үнэн зөвийг гэрчлэхэд хуудас тутмаас 1500-4500 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.4.7.баримт бичгийн орчуулгыг гэрчлэхэд хуудас тутмаас 300-900 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.4.8.баримт бичигт зурсан гарын үсгийг гэрчлэхэд 2500-7500 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.4.9.гэрчлэгдсэн баримт бичгийн хуулбарыг гэрчлэхэд хуудас тутмаас 200-600 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.4.10.үйлчлүүлэгчийн хүсэлтээр үндсэн материалыг шалгахад 7500-22 500 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.4.11.үл хөдлөх эд хөрөнгийн холбогдолтой баримт бичгийг гэрчлэхэд баримт бичигт тусгагдсан үнийн дүнгийн 0.06 хүртэл хувиар;

11.4.12.үл хөдлөх эд хөрөнгийн гэрээг гэрчлэхэд нөхөр, эхнэр, хүүхэд, эцэг, эхийн хувьд гэрээний үнийн дүнгээс 0.035 хүртэл хувиар, бусад хүнд үнийн дүнгийн 0.055 хүртэл хувиар;

11.4.13.энэ хуулийн 11.4.1-11.4.3, 11.4.7-д зааснаас бусад гэрээ, хэлцлийг гэрчлэхэд үнийн дүнгийн 1 000 000 хүртэл төгрөгөөс 0.025 хүртэл хувиар, 1 000 000 төгрөгөөс давсан хэсгээс 0.015 хүртэл хувиар нэмэгдүүлж;

11.4.14.хууль тогтоомжид заасан бусад үйлчилгээ үзүүлэхэд үнийн дүнгийн 1.2 хүртэл хувиар;

11.4.15.хуулийн этгээдийг үүсгэн байгуулах тухай гэрээ, дүрэм гэрчлэхэд хуудас тутмаас 240-720 төгрөг буюу түүнтэй тэнцэх бусад валют;

11.4.16.хуулийн этгээд үүсгэн байгуулах, татан буулгах баримт бичиг гэрчлэхэд 4400-13 200 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.4.17.хуулийн этгээд үүсгэн байгуулах, татан буулгах баримт бичигт өөрчлөлт оруулсан, хугацааг нь сунгасныг гэрчлэхэд 1100-3300 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.4.18.хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөн байгуулах эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг гэрчлэхэд 2000-6000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.4.19.аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл болон зөвшөөрөлтэй холбогдсон баримт бичиг гэрчлэхэд 20 000-60 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.4.20.өв залгамжлах эрх, гэрээслэл гэрчлэхэд 1100-3300 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.4.21.гэр бүлийн гишүүдийн дундаа хамтран болон дундаа хэсгээр өмчлөх эрхийг гэрчлэхэд 1000-2000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют.

11.5.Өв залгамжлал, гэрээслэл, гэр бүлийн гишүүдийн дундаа хамтран болон дундаа хэсгээр өмчлөх эд хөрөнгөөс оногдох хувиа өмчлөх эрх, үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэхтэй холбоотой гэрээ зэрэг тодорхой үнийн дүн, төлбөрийн хэмжээ бүхий бүх төрлийн гэрээ, хэлцлийг гэрчлэхэд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

11.5.1.1000 хүртэл ам.доллартай тэнцэх дүнтэй бол 15 000-45 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.5.2.1001-10000 ам.доллартай тэнцэх үнийн дүнтэй бол 23 000-69 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.5.3.10001-25000 ам.доллартай тэнцэх үнийн дүнтэй бол 30 000-90 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.5.4.25001-100000 ам.доллартай тэнцэх үнийн дүнтэй бол 37 000-111 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.5.5.100001-300000 ам доллартай тэнцэх үнийн дүнтэй бол 45 000-135 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.5.6.300001 болон түүнээс дээш ам.доллартай тэнцэх үнийн дүнтэй бол 60 000 -180 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.5.7.өвлүүлэгчийн нөхөр, эхнэр, эцэг, эхээс бусад хүнд өв залгамжлах эрхийн гэрчилгээ олгоход 100 000-300 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.5.8.аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ, тээврийн хэрэгслийн гэрчилгээ зэрэг үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг нотлох бүх төрлийн баримт бичгийн хуулбарыг гэрчлэхэд 7500-22 500 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют.

[Энэ зүйлийг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

12 дугаар зүйл.Тээврийн болон өөрөө явагч хэрэгслийг бүртгэх, жолоодох зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

12.1.Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийг бүртгэх, жолоодох зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

12.1.1.автотээврийн хэрэгслийн гэрчилгээ, ашиглалтын дэвтэр олгоход 1000-2000 төгрөг;

12.1.2.автотээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх, мэргэшсэн жолоочийн үнэмлэх олгоход 1000-2000 төгрөг;

12.1.3.автотээврийн хэрэгслийн гэрчилгээ, ашиглалтын дэвтрийг алдаж үрэгдүүлэх, гээгдүүлэх, хүчингүй буюу ашиглах боломжгүй болгосноос дахин олгоход 8000-20 000 төгрөг;

12.1.4.өөрөө явагч хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх олгоход 1000-2000 төгрөг.

12.2.Автомашин, өөрөө явагч хэрэгсэл, мотоциклийн дугаар олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

12.2.1.автомашин дугаар олгоход 1000-2200 төгрөг;

12.2.2.өөрөө явагч хэрэгсэл, чиргүүлийн улсын дугаар олгоход 1000-2000 төгрөг;

12.2.3.мотоциклийн улсын дугаар олгоход 1000-2000 төгрөг;

12.2.4.автомашин, өөрөө явагч хэрэгсэл, чиргүүлийн болон мотоциклийн улсын дугаарыг алдаж үрэгдүүлэх, гээгдүүлэх, хүчингүй буюу ашиглах боломжгүй болгосноос дахин олгоход 16 000-40000 төгрөг.

12.3.Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн тээврийн хэрэгсэл өмчилж авсан бол түүнийг зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа орон нутаг дахь байгууллага бүртгэхэд 1000-2000 төгрөгийн тэмдэгтийн хураамж хураана.

12.4.Агаарын хөлөг болон усан онгоцыг бүртгэх, агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ, усан /хөлөг/ онгоцыг бүртгэхэд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

12.4.1.Монгол Улсын иргэн, тус улсад байнга оршин суугаа харьяалалгүй хүн, хуулийн этгээдийн өмчлөлд байгаа агаарын хөлгийг улсын бүртгэлд бүртгэж, үндэсний таних тэмдэг, бүртгэлийн гэрчилгээ олгоход 17 600-44 000 төгрөг;

12.4.2.гадаадын хуулийн этгээд, гадаадын иргэн, харьяалалгүй хүний өмчлөлд байгаа агаарын хөлгийг Монгол Улсын иргэний агаарын тээвэрт ашиглахаар гэрээ байгуулсан нөхцөлд улсын бүртгэлд бүртгэж үндэсний таних тэмдэг, бүртгэлийн гэрчилгээ олгоход 200 000- 500 000 төгрөг;

12.4.3.энэ хуулийн 12.4.2-т заасан гэрчилгээний хугацааг сунгахад 160 000 400 000 төгрөг;

12.4.4.агаарын хөлгийг ашиглалтаас хасах, тус улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулаагүй гадаадын байгууллагад болон Монгол Улсын харьяат бус бөгөөд тус улсад оршин суудаггүй хүнд худалдсан, шилжүүлсэн тохиолдолд улсын бүртгэлээс хасахад 12 000-30 000 төгрөг;

12.4.5.дотоодын усан замын тээврийн хэрэгслийг бүртгэж, дугаар, гэрчилгээ олгоход 4000-10000 төгрөг;

12.4.6.Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн өмчлөлд байгаа болон тэдгээрийн түрээсэлсэн хөлөг онгоцыг Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэхэд 24 000-60 000 төгрөг;

[Энэ заалтыг 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан.](#)

12.4.7.гадаадын хуулийн этгээд, гадаадын иргэн, харьяалалгүй хүний өмчлөлд байгаа болон тэдгээрийн түрээсэлсэн хөлөг онгоцыг Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэхэд 200 000-500 000 төгрөг;

[Энэ заалтыг 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар нэмсэн.](#)

12.4.8.энэ хуулийн 12.4.7-д заасан бүртгэлийн гэрчилгээний хугацааг сунгахад 160 000-400 000 төгрөг.

[Энэ заалтыг 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар нэмсэн.](#)

[Энэ зүйлийг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан.](#)

13 дугаар зүйл. Галт зэвсэг худалдах, эзэмших, улсын хилээр нэвтрүүлэх, галт зэвсэг, сум ашиглан спорт-сургалтын үйл ажиллагаа эрхлэх болон харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

13.1. Галт зэвсэг худалдах, эзэмших, улсын хилээр нэвтрүүлэх, бүртгэх, галт зэвсэг, сум ашиглан спорт-сургалтын зорилгоор үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход доор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

13.1.1. галт зэвсэг, сум импортлох, нийтэд худалдах тусгай зөвшөөрөл олгоход 10 000 000 төгрөг, галт зэвсгийн сум импортлох, нийтэд худалдах тусгай зөвшөөрөл олгоход 5 000 000 төгрөг;

13.1.2. галт зэвсэг үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход 5 000 000 төгрөг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, галт зэвсгийн сум үйлдвэрлэх, дахин цэнэглэх тусгай зөвшөөрөл олгоход 2 500 000 төгрөг;

13.1.3. галт зэвсэг, сум ашиглан спорт-сургалтын зорилгоор үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг;

13.1.4. иргэн, хуулийн этгээдийн өмчлөлд байгаа галт зэвсгийг бүртгэж, гэрчилгээ олгоход нэгж бүрээс 10 000 төгрөг;

13.1.5. галт зэвсгийн шилжилт, хөдөлгөөнийг бүртгэж, гэрчилгээ олгоход 5 000 төгрөг;

13.1.6. гадаадын иргэний галт зэвсгийг бүртгэн, улсын хилээр нэвтрүүлж ан агнах зорилгоор ашиглах зөвшөөрлийн хуудас олгоход 250 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют, спорт-сургалтын /уралдаан, тэмцээнд оролцох/ зорилгоор ашиглах зөвшөөрлийн хуудас олгоход 25 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют.

13.2. Хувийн харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход доор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

13.2.1. хуулийн этгээдэд хувийн харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 2 500 000 төгрөг;

13.2.2. хуулийн этгээдэд хувийн харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сунгахад 250 000 төгрөг;

13.2.3. иргэнд хувийн хамгаалалтын мэргэжлийн тусгай зөвшөөрөл олгоход 250 000 төгрөг.

[Энэ зүйлийг 2015 оны 8 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан.](#)

14 дүгээр зүйл. Сонин, сэтгүүл, радио, телевизийг улсын бүртгэлд бүртгэхэд хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

14.1. Сонин, сэтгүүл, радио, телевизийг улсын бүртгэлд бүртгэхэд доор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

14.1.1. сонин, сэтгүүлийг бүртгэж, гэрчилгээ олгоход 8800-22 000 төгрөг;

14.1.2. олон нийтийн болон хувийн радиог бүртгэхэд 12 800-32 000 төгрөг;

14.1.3. олон нийтийн болон хувийн телевизийг бүртгэхэд 40 000-100 000 төгрөг;

14.1.4. кабелийн телевизийг бүртгэхэд 48 000-120 000 төгрөг;

14.1.5. сонин, сэтгүүл, радио, телевиз, кабелийн телевизийн бүртгэлд өөрчлөлт-өрснийг бүртгэхэд 8000-20 000 төгрөг.

[Энэ зүйлийг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан ба 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон.](#)

15 дугаар зүйл. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээнд хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

15.1.Хуулийн этгээдийн эрх, үүрэг үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болохтой холбоотой бүртгэлийн үйл ажиллагаанд доор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

- 15.1.1.хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэхэд 44 000 төгрөг;
- 15.1.2.хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрыг улсын бүртгэлд бүртгэхэд 20 000 төгрөг;
- 15.1.3.хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэхэд 10 000 төгрөг;
- 15.1.4.улсын бүртгэлийн мэдээллээс лавлагаа олгоход 5 000 төгрөг.

15.2.Шашны байгууллагыг улсын бүртгэлд бүртгэхэд доор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

[/Энэ хэсэгт 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

- 15.2.1.улс төрийн намыг бүртгэж, гэрчилгээ олгоход 60 000-150 000 төгрөг;
[/Энэ заалтыг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд т ооцсон./](#)
- 15.2.2.улс төрийн намын нэр-сольсныг бүртгэхэд 20 000-50 000 төгрөг;
[/Энэ заалтыг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд т ооцсон./](#)
- 15.2.3.шашны байгууллагыг бүртгэхэд 200 000 төгрөг;
- 15.2.4.шашны байгууллагын мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэхэд 40 000 төгрөг;
- 15.2.5.шашны байгууллагын гэрчилгээний хугацаа сунгахад 80 000 төгрөг.

15.3.Гадаадын байгууллага, түүний салбар, төлөөлөгчийн газар болон гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэхэд доор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

- 15.3.1.гадаадын хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрыг бүртгэхэд 1 100 000 төгрөг;
- 15.3.2.гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэхэд 750 000 төгрөг;
- 15.3.3.гадаадын хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрын баримт бичигт оруулсан өөрчлөлтийг бүртгэхэд 35 000 төгрөг;
- 15.3.4.гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн баримт бичигт оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэхэд 40 000 төгрөг;
- 15.3.5.гадаадын хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа явуулах хугацаа сунгахад 750 000 төгрөг;
- 15.3.6.гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн үйл ажиллагаа явуулах хугацаа сунгахад 75 000 төгрөг;
- 15.3.7.гадаадын хөрөнгө оруулалттай банкны төлөөлөгчийн газрыг бүртгүүлэхэд 1 800 000 төгрөг.
[/Энэ зүйлийг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан ба 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

16 дугаар зүйл.Мөнгөл Улсын нутаг дэвсгэрт гадаадын байгууллага, түүний төлөөлөгчийн газар ажиллуулах, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулах зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

16.1.Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд байгуулах, хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар ажиллуулах зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

- 16.1.1.салбар, төлөөлөгчийн газар, нэгж ажиллуулахад 440 000-1 100 000 төгрөг;
- 16.1.2.салбар, төлөөлөгчийн газрын ажиллах хугацааг сунгахад 300 000-750 000 төгрөг;
- 16.1.3.гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулахад 300 000-750 000 төгрөг;
- 16.1.4.гэрчилгээний хугацааг сунгахад 30 000-75 000 төгрөг;
- 16.1.5.гэрчилгээг сольж олгоход анх олгоход хураасан тэмдэгтийн хураамж дээр 1.5 дахин нэмэгдүүлсэн хэмжээгээр;
- 16.1.6.гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын гэрээ, дүрэмд орсон өөрчлөлтийг бүртгэхэд 14 000-35 000 төгрөг;
- 16.1.7.гадаадын хөрөнгө оруулалттай банк байгуулах зөвшөөрөл олгоход 1 120 000-2 800 000 төгрөг;
- 16.1.8.гадаадын хөрөнгө оруулалттай банкны салбар, төлөөлөгчийн газар ажиллуулах зөвшөөрөл олгоход 720 000-1 800 000 төгрөг.

[/Энэ зүйлийг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

16¹ дүгээр зүйл. Улс төрийн намыг бүртгэхэд хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

[/Энэ зүйлийг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

16¹.1. Намыг бүртгэхэд доор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

[/Энэ хэсгийг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

16¹.1.1. гэрчилгээ олгоход 300 000 төгрөг;

[/Энэ заалтыг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

16¹.1.2. намын нэр сольсныг бүртгэхэд 150 000 төгрөг.

[/Энэ заалтыг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

17 дугаар зүйл. Банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

17.1. Банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

17.1.1. банк байгуулах тусгай зөвшөөрөл олгоход 480 000-1 200 000 төгрөг;

17.1.2. мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход 200 000-500 000 төгрөг;

[/Энэ заалтад 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

17.1.3. зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход 300 000-750 000 төгрөг;

[/Энэ заалтад 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

17.1.4. төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход 18 000-45 000 төгрөг;

[/Энэ заалтад 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

17.1.5. өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд баталгаа, батлан даалт гаргах зөвшөөрөл олгоход 74 000-185 000 төгрөг;

[/Энэ заалтад 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

17.1.6. гадаад валют худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах зөвшөөрөл олгоход 70 000-175 000 төгрөг;

[/Энэ заалтад 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

17.1.7. үнэт металл, эрдэнийн чулуу худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах тусгай зөвшөөрөл олгоход 100 000-250 000 төгрөг;

17.1.8. үнэт зүйл хадгалах зөвшөөрөл олгоход 100 000-250 000 төгрөг;

[/Энэ заалтад 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

17.1.9. гадаад төлбөр тооцоо хийх зөвшөөрөл олгоход 180 000-450 000 төгрөг;

[/Энэ заалтад 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

17.1.10. үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах зөвшөөрөл олгоход 48 000-120 000 төгрөг;

[/Энэ заалтад 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

17.1.11. санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход 180 000-450 000 төгрөг;

[/Энэ заалтад 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

17.1.12. зээл болон санхүүгийн бусад хэрэгслийг худалдах, худалдан авах зөвшөөрөл олгоход 48 000-120 000 төгрөг;

[/Энэ заалтад 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

17.1.13. гадаад улсад банк байгуулах зөвшөөрөл олгоход 1 280 000-3 200 000 төгрөг;

17.1.14. гадаад улсад банкны салбар байгуулах зөвшөөрөл олгоход 480 000-1 200 000 төгрөг.

17.1.15. энэ хуулийн 17.1.1-17.1.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахад 40 000-200 000 төгрөг;

17.1.16. хууль тогтоомжоор хориглоогүй, Монголбанкнаас зөвшөөрсөн санхүүгийн бусад ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 52 000-130 000 төгрөг.

[/Энэ зүйлийг 2011 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

18 дугаар зүйл. Банкнаас бусад санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

18.1. Банкнаас бусад санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

18.1.1. ердийн, урт хугацааны, давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 400 000-1 000 000 төгрөг;

[/Энэ заалтад 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

18.1.2. даатгалын үйл ажиллагаа эрхлэх эрхийг сэргээхэд 200 000-500 000 төгрөг;

[/Энэ заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд т.ооцсон./](#)

- 18.1.3.давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 400 000-1 000 000 төгрөг;
[/Энэ заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)
- 18.1.4.актуарчийн эрх олгоход 140 000-350 000 төгрөг;
[/Энэ заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)
- 18.1.5.даатгагчид өөрийн салбар, төлөөлөгчийн газраа гадаад улсын нутаг дэвсгэрт нээх, түүгээр дамжуулан даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход 112 000-280 000 төгрөг;
[/Энэ заалтад 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)
- 18.1.6.даатгагчийн үйл ажиллагааны аливаа хэсгийг бусад этгээдэд шилжүүлэх болон бусад этгээдийн үйл ажиллагаатай нэгтгэх зөвшөөрөл авахад 40 000-100 000 төгрөг;
[/Энэ заалтад 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)
- 18.1.7.гадаадын даатгагч Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход 1 800 000-4 500 000 төгрөг.
[/Энэ заалтад 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)
- 18.2.Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:
- 18.2.1.даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрөл олгоход 18 000-45 000 төгрөг;
- 18.2.2.даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөл олгоход 26 000-65 000 төгрөг;
- 18.2.3.даатгалын хохирол үнэлэгчийн тусгай зөвшөөрөл олгоход 34 000-85 000 төгрөг.
- 18.3.Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:
[/Энэ хэсэгт 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)
- 18.3.1.зээл олгох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 120 000-300 000 төгрөг;
[/Энэ заалтад 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)
- 18.3.2.факторингийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 100 000-250 000 төгрөг;
[/Энэ заалтад 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)
- 18.3.3.хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 80 000-200 000 төгрөг;
[/Энэ заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)
- 18.3.4.төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход 400 000-1 000 000 төгрөг;
[/Энэ заалтад 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)
- 18.3.5.төлбөр тооцооны хэрэгсэл гаргах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход 200 000-500 000 төгрөг;
[/Энэ заалтад 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)
- 18.3.6.цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 200 000-500 000 төгрөг;
- 18.3.7.гадаад валютын арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 800 000-2 000 000 төгрөг;
[/Энэ заалтад 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)
- 18.3.8.итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 200 000-500 000 төгрөг;
[/Энэ заалтад 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)
- 18.3.9.богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход 200 000-500 000 төгрөг;
[/Энэ заалтад 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)
- 18.3.10.үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход 200 000-500 000 төгрөг;
[/Энэ заалтад 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)
- 18.3.11.банк бус санхүүгийн байгууллагын нэр, байршлыг өөрчлөх зөвшөөрөл олгоход 4000-10000 төгрөг;
- 18.3.12.банк бус санхүүгийн байгууллагыг өөрчлөн байгуулах, татан буулгах зөвшөөрлийг олгоход 24 000-60 000 төгрөг;
[/Энэ заалтад 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)
- 18.3.13.үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгож, бүртгэхэд 13 000-30 000 төгрөг;
[/Энэ заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)
- 18.3.14.үнэт цаасны арилжааны тооцооны, төлбөрийн, төвлөрсөн хадгаламжийн, өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 40 000-100 000 төгрөг;
[/Энэ заалтад 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)
- 18.3.15.хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 60 000-150 000 төгрөг;

[/Энэ заал т ад 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

18.3.16.үнэт цаасны итгэмжлэн удирдах, санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох, кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 48 000-120 000 төгрөг;

[/Энэ заал т ад 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

18.3.17.андеррайтер, брокер, дилер, үнэт цаасны арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 58 000-145 000 төгрөг;

18.3.18.хөрөнгө оруулалтын менежментийн болон хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 112 000-280 000 төгрөг;

